

“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН ХОЙШЛОГДСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 05 сарын 06 өдөр

Улаанбаатар хот

Хот Девелопмент ХК-ийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 05 сарын 06-ны өдрийн 10:00 цагт цахимаар эхлэв.

Хот Девелопмент ХК нь нийт 8,470,054 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаатай байна.

Хот Девелопмент ХК-ийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй хувьцааны 99.09% буюу 8,392,722 ширхэг хувьцаа эзэмшиж буй 1 хувьцаа эзэмшигч оролцов. Хуралд оролцсон 1 хувьцаа эзэмшигч саналын хуудсыг ирүүлэн саналаа өгсөн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц 99.09%-иар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр болов.

(Компанийн тухай хуулийн 69.1-т “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.”

Компанийн тухай хуулийн 69.2-т “Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн хувийг энэ хуулийн 69.1-д зааснаас дээгүүр тогтоож болно.”

Хот Девелопмент ХК-ийн компанийн дүрмийн 3.14-т “Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэж тус тус заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хангагдсан гэж үзэв.)

Саналын хуудсаар дараах асуудлуудаар санал хураав. Үүнд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2021 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг батлах тухай;

Тооллогын комисс нийт 8,392,722 ширхэг хувьцаатай 1 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг саналын хуудсаар хүлээн авсан. Хуралд оролцсон бүх хувьцаа эзэмшигчид саналын хуудас ирүүлсэн байна.

Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дараах асуудлуудад хувьцаа эзэмшигчид ердийн аргаар санал өгөх байв. Үүнд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2021 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;